

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/137-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК Утас: 99102291 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № 107-2022/135-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

МАНДАЛ СУМЫН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ШИНЭЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,956,255.20	56,779,916.60
35	БАРАА МАТЕРИАЛ	64,956,255.20	56,779,916.60
35100	Түүхий эд материал	25,500.00	114,000.00
35130	Эм боох материал	25,500.00	114,000.00
35400	Хангамжийн материал	64,930,755.20	56,665,916.60
35410	Бичиг хэргийн материал	110,000.00	117,000.00
35420	Аж ахуйн материал	62,319,234.20	54,721,855.60
35450	Барилгын засварын материал	2,501,521.00	1,465,721.00
35460	Хүнсний материал	0.00	361,340.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,353,354,479.08	1,339,318,065.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,353,354,479.08	1,339,318,065.86
39200	Биет хөрөнгө	1,285,060,729.10	1,271,186,815.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,088,757,868.50	1,088,757,868.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65,734,627.28	-88,591,076.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	52,110,312.40	40,901,364.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,547,405.66	-9,280,377.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,742,241.76	49,330,953.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,309,681.29	-22,377,871.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,059,984.40	32,987,984.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,910,534.81	-12,439,600.37
39216	Дуусаагүй барилга, байгууламж	188,731,873.00	188,731,873.00
39217	Ном	3,160,698.08	3,165,698.08
39300	Биет бус хөрөнгө	68,293,749.98	68,131,249.94
39301	Программ хангамж	1,500,000.00	1,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-406,250.02	-468,750.06
39303	Бусад биет бус хөрөнгө	67,200,000.00	67,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,418,310,734.28	1,396,097,982.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,418,310,734.28	1,396,097,982.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,418,310,734.28	1,396,097,982.46
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	163,386,561.24	163,386,561.24
51200	Хуримтлагдсан үр дүн	1,071,458,844.97	1,049,292,656.48
51210	Өмнөх үеийн үр дүн	900,277,344.98	1,071,505,408.30
51220	Тайлант үеийн үр дүн	171,181,499.99	-22,212,751.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	183,465,328.07	183,418,764.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,418,310,734.28	1,396,097,982.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

T2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	694,819,691.00	489,445,228.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	194,226,813.00	7,855,639.00
120	Нийтлэг татварын бус орлого	194,226,813.00	7,855,639.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	193,980,373.00	6,886,393.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	211,440.00	969,246.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,592,878.00	481,589,589.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,114,800.00	418,808,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,114,800.00	418,808,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4,381,307.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	394,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,987,307.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,478,078.00	58,399,782.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,478,078.00	58,399,782.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	523,638,191.01	511,657,980.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,638,191.01	511,657,980.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,808,364.68	487,425,168.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,037,925.86	314,184,318.00
210101	Үндсэн цалин	236,280,686.39	217,481,730.00
210102	Нэмэгдэл	60,671,471.26	79,598,528.00
210104	Урамшуулал	15,085,768.21	17,104,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,894,362.81	42,117,857.00
210201	Тэтгэврийн даатгал	26,443,073.45	29,230,027.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,215,926.44	3,734,241.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,541,606.91	2,520,701.60
210204	Ажилгүйдлийн даатгал	806,314.82	622,848.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,887,441.19	6,010,038.54

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,881,928.00	56,856,987.28
210301	Гэрэл, цахилгаан	3,383,003.00	2,763,747.28
210302	Түлш, халаалт	45,671,255.00	53,397,600.00
210303	Цэвэр, бохир ус	827,670.00	695,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,217,988.80	14,898,824.60
210401	Бичиг хэрэг	155,500.00	2,468,800.00
210402	Тээвэр, шатахуун	527,500.00	591,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,900.00	550,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	659,400.00	394,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,929,600.00	10,894,424.60
210408	Бараа материал акталсны зардал	2,859,088.80	0.00
2105	Нормативт зардал	25,657,124.99	18,968,975.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,200.00	17,500.00
210502	Хоол, хүнс	24,725,224.99	18,461,475.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	830,700.00	490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,033,150.00	4,473,400.00
210604	Урсгал засвар	6,033,150.00	4,473,400.00
2107	Томилолт, зочны зардал	346,900.00	280,000.00
210702	Дотоод албан томилолт	346,900.00	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	680,500.00	1,421,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,500.00	449,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,058,484.22	34,223,706.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	705,900.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,459,400.00	300,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,893,184.22	33,922,806.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,829,826.33	24,232,812.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,829,826.33	24,232,812.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,829,826.33	24,232,812.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	171,181,499.99	-22,212,751.82
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	171,181,499.99	-22,212,751.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,386,561.24	183,465,328.07	900,277,344.98	1,247,129,234.29
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	163,386,561.24	183,465,328.07	900,277,344.98	1,247,129,234.29
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	171,181,499.99	171,181,499.99
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,386,561.24	183,465,328.07	1,071,458,844.97	1,418,310,734.28
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	163,386,561.24	183,465,328.07	1,071,458,844.97	1,418,310,734.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	46,563.33	46,563.33
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	163,386,561.24	183,465,328.07	1,071,505,408.30	1,418,357,297.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-46,563.33	0.00	-46,563.33
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,212,751.82	-22,212,751.82
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	163,386,561.24	183,418,764.74	1,049,292,656.48	1,396,097,982.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	500,627,878.00	481,589,589.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,627,878.00	481,589,589.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,114,800.00	418,808,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,114,800.00	418,808,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	4,381,307.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	394,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	3,987,307.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,478,078.00	58,399,782.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,478,078.00	58,399,782.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,870,678.00	468,589,589.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,870,678.00	468,589,589.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,040,851.67	444,356,777.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,037,925.86	314,184,318.00
210101	Үндсэн цалин	236,280,686.39	217,481,730.00
210102	Нэмэгдэл	60,671,471.26	79,598,528.00
210104	Урамшуулал	15,085,768.21	17,104,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,894,362.81	42,117,857.00
210201	Тэтгэврийн даатгал	26,443,073.45	29,230,027.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,215,926.44	3,734,241.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,541,606.91	2,520,701.60
210204	Ажилгүйдлийн даатгал	806,314.82	622,848.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,887,441.19	6,010,038.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,881,928.00	56,856,987.28
210301	Гэрэл, цахилгаан	3,383,003.00	2,763,747.28
210302	Түлш, халаалт	45,671,255.00	53,397,600.00
210303	Цэвэр, бохир ус	827,670.00	695,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,303,800.00	6,091,100.00
210401	Бичиг хэрэг	249,500.00	1,966,500.00
210402	Тээвэр, шатахуун	527,500.00	591,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,900.00	550,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,150,000.00	864,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,289,900.00	2,119,000.00
2105	Нормативт зардал	25,711,385.00	19,046,615.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,700.00	106,000.00
210502	Хоол, хүнс	24,527,985.00	18,822,815.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,080,700.00	117,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,078,150.00	3,437,600.00
210604	Урсгал засвар	6,078,150.00	3,437,600.00
2107	Томилолт, зочны зардал	346,900.00	280,000.00
210702	Дотоод албан томилолт	346,900.00	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	680,500.00	1,421,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,500.00	449,100.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,105,900.00	921,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	705,900.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	921,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,829,826.33	24,232,812.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,829,826.33	24,232,812.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,829,826.33	24,232,812.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,757,200.00	13,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,757,200.00	13,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,757,200.00	13,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,757,200.00	13,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,757,200.00	13,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,757,200.00	-13,000,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	484,911,600.00	452,975,470.00	31,936,130.00	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,911,600.00	452,975,470.00	31,936,130.00	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,911,600.00	452,975,470.00	31,936,130.00	93.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,368,100.00	311,039,605.00	8,328,495.00	97.4
210101	Үндсэн цалин	230,362,600.00	214,337,017.00	16,025,583.00	93.0
210102	Нэмэгдэл	74,592,000.00	79,598,528.00	-5,006,528.00	106.7
210104	Урамшуулал	14,413,500.00	17,104,060.00	-2,690,560.00	118.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,254,200.00	41,724,768.00	1,529,432.00	96.5
210201	Тэтгэврийн даатгал	29,979,800.00	28,913,864.43	1,065,935.57	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,318,600.00	3,715,010.21	-396,410.21	111.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,654,900.00	2,505,316.60	149,583.40	94.4
210204	Ажилгүйдлийн даатгал	663,700.00	598,416.22	65,283.78	90.5
210205	Эрүүл мэндийн даатгал	6,637,200.00	5,992,160.54	645,039.46	90.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,110,800.00	56,407,482.00	7,703,318.00	87.9
210301	Гэрэл, цахилгаан	7,951,800.00	2,314,242.00	5,637,558.00	29.1

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	53,397,600.00	53,397,600.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,761,400.00	695,640.00	2,065,760.00	25.2
2104	Хангамж, бараа материалын зардал	5,697,100.00	5,697,100.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,966,500.00	1,966,500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	470,500.00	591,600.00	-121,100.00	125.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	550,000.00	50,000.00	91.7
210404	Ном, хэвлэл	121,100.00	0.00	121,100.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	739,100.00	470,000.00	269,100.00	63.59
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,799,900.00	2,119,000.00	-319,100.00	117.7
2105	Нормативт зардал	33,381,300.00	19,046,615.00	14,334,685.00	57.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,200.00	106,000.00	200.00	99.8
210502	Хоол, хүнс	33,157,300.00	18,822,815.00	14,334,485.00	56.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	117,800.00	117,800.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,437,600.00	16,437,600.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,437,600.00	3,437,600.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	320,200.00	280,000.00	40,200.00	87.4
210702	Дотоод албан томилолт	320,200.00	280,000.00	40,200.00	87.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,421,100.00	1,421,100.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	449,100.00	449,100.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	972,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	921,200.00	921,200.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	921,200.00	921,200.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	484,911,600.00	452,975,470.00	31,936,130.00	93.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,808,500.00	394,575,688.00	24,232,812.00	94.2
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,808,500.00	394,575,688.00	24,232,812.00	94.1

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	66,103,100.00	58,399,782.00	7,703,318.00	88.3
320001	Орон нутгийн төсвөөс	66,103,100.00	58,399,782.00	7,703,318.00	88.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	293.00	125.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30.00	30.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	22.00		
620003	Үйлчлэх ажилтан	17.00	7.00		
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	232.00	64.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,381,307.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,381,307.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,381,307.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,144,713.00
210101	Үндсэн цалин	3,144,713.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	393,089.00
210201	Тэтгэврийн даатгал	316,163.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,231.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,385.00
210204	Ажилгүйдлийн даатгал	24,432.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,878.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	449,505.28
210301	Гэрэл, цахилгаан	449,505.28
2104	Хангамж, бараа материалын зардал	394,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	394,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,381,307.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,381,307.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	394,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,987,307.28
--------	--	--------------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн /цаашид Мандал сумын 5 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн талаар болон худалдан авалтын төлбөрийн баримтын цахим системийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймгийн дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор, аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 5 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүй, урлал, уран сайхан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, байгаль орчин, юмс үзэгдлийн талаар шинжлэх ухаанч, зөв ойлголтыг олгох, бие даасан чанарыг хөгжүүлэх, дэлхийн иргэн болон хүн болгож төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, боловсрол эзэмших орчин бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжлийн түвшинг улсын дунджаас дээгүүр үзүүлэлтэд хүргэх.
- СӨНХ-ийн хэрэгцээ сонирхолд тулгуурлан хөгжүүлэх сургалтын технологийг шинэчлэн боловсронгуй болгох.

- Боловсон хүчний нөөцийн зохицуулалт, бүтээмж чанарыг дээшлүүлэх, улмаар бусад цэцэрлэгтэй шударгаар өрсөлдөх чадварыг бий болгох.
- Өдөр тутмын хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг чанаржуулж сургалтын чанарыг 98% хүргэх, үр дүнг сайжруулах, СӨБ-д хамрагдаагүй хүүхдийг бүрэн хамруулах.
- Цэцэрлэгийн санхүүг бэхжүүлэх, өөрийн орлогыг нэмэгдүүлэх, төсөв хөрөнгийг үр бүтээлтэй зарцуулах.
- Оновчтой зохион байгуулж менежментийг шинэчлэх, хамтын удирдлагыг хэрэгжүүлэх, үүрэг даалгаврыг тодорхой болгох, хариуцлага тооцох, хариуцлага хүлээж сургах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал

дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 5 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 511,657.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,116.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн байдлыг 70 хувиар буюу 3,581.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,212.8 мянган төгрөгөөр 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	64,956.2	56,779.9	(8,176.3)
Бусад эргэлтийн хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	1,353,354.5	1,339,318,0	(14,036.5)
Нийт хөрөнгө	1,418,310.7	1,396,097.9	(22,212.8)
Богино хугацаат ер төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,418,310.7	1,396,097.9	(22,212.8)
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,418,310.7	1,396,097.9	(22,212.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 56,779.9 мянган төгрөг болж 8,176.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,472,475.7 мянган төгрөг / *анхны өртгөөр* / болж, 16,787.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 13,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон БСГ-аас 5.0 мянган төгрөгийн ном, аж ахуйн нэгжээс 499.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусган, аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу 4,254.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үнийг бууруулан бүртгэж авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,396,097.9 мянган төгрөг болж 22,212.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 205,374.5 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй болон тусламж санхүүжилтийн орлого буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 16,089.4 мянган төгрөгөөр буурсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд буурснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 557,921.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 73,009.0 мянган төгрөгөөр бууруулж 484,911.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **484,911.6** мянган төгрөгийн төсөв баталснаас 418,808.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 66,103.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 418,808.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 58,399.8 мянган төгрөг, нийт 477,208.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 452,975.5 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 24,232.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **452,975.5** мянган төгрөг буюу 93.4 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 9,857.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,703.3 мянган төгрөгөөр, нормативт

зардал 14,334.7 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 40.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БСГ-аас ариутгалын зардалд 394.0 мянган төгрөг, Хэрх тосгоны ЭМТ-өөс 3,987.3 мянган төгрөгийн ковидын илүү цагийн хөлс орж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын 5 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 484,911.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 452,975.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.6 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 73,577.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагад хамааралгүй 5,898.0 мянган төгрөгийн худалдан авалт илүү шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын нийт 67,679.1 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрч, зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

1 Төлбөрийн баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 67,679.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт*”

юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар цэцэрлэг	2	67,679.1	-	-	-	-	-	-	3	67,679.1

